БАТЛАВ.
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Т.ЖАМБАЛЦЭРЭН

ХАРГАНА ТҮРҮҮ УСЛАЛТЫН СИСТЕМ
/ГОВЬ-АЛТАЙ, ДАРВИ СУМ/ АЖЛЫН ДААЛГАВАР
АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУГААР УТ2601900257

2026 оны 01-р сарын 23 өдөр Улаанбаатар хот

1	Үндэслэл	- “2026 оны төсвийн тухай хууль”-ийн УТ2601900257 Харгана түрүү услалтын систем /Говь-Алтай, Дарви сум/ - Монгол Улсын ур хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” баримт бичгийн 6.2.11, 8.3.4-д заасан зорилтууд - Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын 3.2 дахь заалт; - “Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.6, 2.1-д заасан зорилтууд; - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.8, 3.3.4.22-т тусгагдсан тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх, малчдын тэжээлийн баталгаат хангамжийг сайжруулах.
2	Байршил	- Говь-Алтай аймгийн Дарви сум
3	Зорилго, ач холбогдол	- Говь-Алтай аймгийн Дарви сумын нутагт байрлах “Харгана түрүү услалтын систем”-ийн барилга байгууламжын шинэчлэлийн хүрээнд 181 га талбайн услалтын систем байгуулж малын тэжээл тариалах замаар орон нутгийн болон бүс нутгийн хүн, амын хэрэгцээ, малын тэжээл хангамжид нийлүүлэх.
4	Зориулалт, хүчин чадал	<u>Зориулалт;</u> Говь-Алтай аймгийн Дарви сумын нутагт байрлах “Харгана түрүү” услалтын системийн барилга угсралтын ажлын хүрээнд ус авах толгойн барилга, ус өгөх хоолой, усан сан, гол, дөхүүлэх болон хуваарилах сувгуудийг сэргээн засварлаж, шинэчлэх замаар 181 га малын тэжээлийн талбайг усалгаатай тариалангийн эргэлтэнд нэмж оруулна. <u>Хүчин чадал;</u> - Услагаанд ашиглах талбай: 173 га

5	Барилга байгууламжийн ангилал	- Усны барилга байгууламж
6	Барилга угсралтын байгууллагад тавигдах үндсэн шаардлана	**Барилга хот байгуулалтын яамнаас олгодог;** - БА -3.2 “Усны барилга Байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил” болон түүнээс дээш.
7	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	- Ус авах толгойн барилга: - Ус өгөх хоолой – 510 метр PE100 SDR17 OD400мм - Ус хуримтлуулах, дамжуулах усан сан: 1382,2 м^3 - Ус хуримтлуулах, дамжуулах усан сан: 17814,6 м^3 - Гол суваг: 2571,5 м b=0.6м h=0.6м - Хуваарилах суваг: 6956м b=0.6м h=0.3м - Дөхүүлэх суваг: 60м - Тохируулах худаг: 1 ширхэг - Ус авах худаг: 2 ширхэг
8	Барилгын үндсэн бүтэц, материал	- Барилга хөгжлийн төвийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 0267/2025 дугаар магадлалын дүгнэлтээр батлагдсан зураг төсөл, барилгын норм, дүрэм баримтлах
9	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	**Усны барилга, байгууламж;** - Инженерийн бэлтгэл арга хэмжээ авах. - Ус зайлуулах, цуглуулах хамгаалалтын арга хэмжээ авах.
10	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай зам, тээвэр	- Зураг, төслийн хүрээнд гүйцэтгэх
11	Зураг төсөл, магадлалын дүгнэт:	- Барилга хөгжлийн төвийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 0267/2025 дугаар магадлалын дүгнэлтээр батлагдсан зураг төсөл
12	Барилга угсралтад тавигдах үндсэн шаардлага	- Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог тусгай зөвшөөрлийн хүрээнд ЗТ-3.2 “Усны барилга байгууламжийн зураг төсөл” болон түүнээс дээш байх.
13	Захиалагч байгууллага	- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам.
14	Онцгой нөхцөл	- Монгол Улсын хууль, Барилгын норм ба дүрмийг баримталсан байх. - Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн аюулгүй ажиллагаанд тавигдах олон улсын болон Монгол Улсын холбогдох стандартын шаардлага, норм, дүрмийг баримталсан байх.
15	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Шаардлагагүй.
16	Байгаль орчны үнэлгээ	- Шаардлагагүй.

17	Цахилгаан хангамж	- Техникийн нөхцөл, батлагдсан зураг төслийн хүрээнд